



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2004 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Хүн амын амьжиргааны доод түвшинг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 4, 5 дугаар заалт, Үндэсний статистикийн газрын даргын зөвлөлийн 2004 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Хүн амын амьжиргааны доод түвшин”-гийн 2004 онд мөрдөх хэмжээг хавсралтад дурьдсаны дагуу бүс нутгийн ялгавартайгаар баталж мөрдүүлсүгэй.

Хоёр. Бүс нутгаар шинэчлэн тогтоосон “Хүн амын амьжиргааны доод түвшин”-гийн хэмжээний талаар холбогдох байгууллагуудад танилцуулж, нийтэд мэдээллэхийг Хүн ам, нийгмийн статистикийн газар /Б.Цэрэнханд/, Тамгын газар /Х.Бажийхүү/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хүн амын амьжиргааны доод түвшинг батлах тухай” ҮСГ-ын даргын 2003 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 80 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

П.БЯМБАЦЭРЭН



ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	20200
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	20600
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	20600
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	21200
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	26500